



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 02

Номгон

“Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн  
хэрэгжүүлэх хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг мэдээллийн технологит шилжүүлэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Төрийн болон байгууллагын архивын цаасан суурьт баримтыг цахим санд шилжүүлэх “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хугацааг 2017-2019 онуудад сунгаж хэрэгжүүлсүгэй.

2.“Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв санхүүг шийдвэрлэж, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан, хэрэгжилт үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/ -д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116177



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 03

Номгон

“Гадаад харилцаа, аялал жуулчлалын  
алба” байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн II хуралдаанаар батлагдсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2 дугаар бүлгийн 85 дахь заалт, аймгийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2-ын 69 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн гадаад харилцаа, аялал жуулчлалын бодлогыг боловсруулан шийдвэрлүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба”-ыг аймгийн Засаг дарга дэргэдэх агентлагын статустайгаар байгуулсугай.

2. “Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба”-ны бүтэц, орон тоо, чиг үүргийг баталж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116159



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 04

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1, 18.1.3-ын "л" дэх заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аудитын газрын худалдан авсан УАЗ-220692-0330 маркийн D-2890 хөдөлгүүрийн багтаамжтай 374100C0483483 арлын дугаартай цагаан саарал өнгийн 80-08 БНХ улсын дугаартай пургон автомашины чанар байдалд үнэлэлт, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч М.Мөнхбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Гишүүд: С.Готов-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Л.Доржханд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Амармөнх-Аймгийн Авто тээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер

Б.Бямбаа Хонгорын үр сад –Аудит ХХК-ний захирал, үнэлгээчин

2. Худалдан авсан автомашинд үзлэг оношлогоо хийлгэж, үнэлгээ тогтоолгож, ажлын хэсгийн дүгнэлт, мэдээллийг бэлтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд 2017 оны 01 дүгээр сарын 20-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /М.Мөнхбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР